


Дасгал даалгаврууд

# Эхийн гол утгыг түлхүүр өгүүлбэрээр тодорхойлоорой.



| Цогцол-<br>борын<br>дугаар | Түлхүүр үг                                                                  | Түлхүүр өгүүлбэр                                                                                                                                                            |
|----------------------------|-----------------------------------------------------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| I                          | Их газарын чулуу,<br>тогтоц, үзэсгэлэн,<br>газар зүйн онцлог,<br>хамгаалалт | <b>Их газарын чулуу</b> нь байц <b>тогтоцтой</b> .<br>Байгалийн <b>үзэсгэлэн, газар зүйн<br/>онцлогийг</b> нь хадгалах зорилгоор<br>улсын тусгай <b>хамгаалалтад</b> авчээ. |
| II                         | уул                                                                         |                                                                                                                                                                             |
| III                        | ашигт малтмал                                                               |                                                                                                                                                                             |
| IV                         | ургамал                                                                     |                                                                                                                                                                             |
| V                          | ан амьтан                                                                   |                                                                                                                                                                             |
| VI                         | байгалийн урлал                                                             | Өвөрмөц сонин тогтоц бүхий <b>байгалийн<br/>урлал</b> юм.                                                                                                                   |

# Баримтын санааг агуулсан түлхүүр өгүүлбэр мөн эсэхийг шинжлээрэй.



Арван хоёр цаг бол монгол зурхайн ёсны цаг. Хоногийг 12 амьтны нэрээр нэрлэж, 12 цагт хуваадаг. Хоногийн 12 цагийг одоо нийтээр хэрэглэж байгаа 24 цагтай харьцуулбал 23-01 цагийг хулгана, 01-03 цагийг үхэр, 03-05 цагийг барс, 05-07 цагийг туулай, 07-09 цагийг луу, 09-11 цагийг могой, 11-13 цагийг морин, 13-15 цагийг хонин, 15-17 цагийг бичин, 17-19 цагийг тахиа, 19-21 цагийг нохой, 21-23 цагийг гахай гэж тус тус нэрлэн хэрэглэсээр иржээ.



**Дэлхий дээр 118 элемент нээгдээд байгаа бөгөөд эдгээр элементээс бүх юмс, эд зүйл бүтнэ.** Ус хатуу, шингэн, хийн гурван төлөвтэй. Нэг төлвөөс нөгөөд шилжихдээ байнга цэвэршиж эрүүлжиж байдаг. Ямар ч бодис биет хөрөхдөө агшдаг, харин ус тэлдэг. Усны хувийн дулаан багтаамж бусад биетийн хувийн дулаан багтаамжтай харьцуулахад онцгой их. Ус бол хамгийн сайн уусгагч. Усны гадаргуугийн талбайн татах хүч бүх шингэнийхээс хамгийн их.

## Дараах 2 баримтыг уншаад, түлхүүр өгүүлбэрийг олоорой.

Хэрэв та барьж байгаа юмаа алдвал тэр чинь газарт л унана. Энэ бол ямар ч биетийг дэлхий рүү татдаг, татах хүч нэртэй үл үзэгдэгч хүчний илрэл юм.

Татах хүч байгаагүй сэн бол биетүүд дэлхийн гадаргуу дээр тогтож чадахгүй сансар руу нисэн одох байсан.

400 орчим жилийн тэртээ Галилей унаж байгаа биетийн хурд нэмэгддэг, өөрөөр хэлбэл хурдатгал үүсдэгийг нээжээ. Тэрбээр хэлбэр хэмжээгээрээ ижил ч хүнд хөнгөн зүйлүүд адилхан хугацаанд газарт хүрдгийг мөн тогтоосон байна.

Тэнгэрийн амьтныг эс тооцвол газарт дайсан ховор. Шувууд түүнд халтай. Бүргэд, тас, сар гээд томчууд түүнийг үзэхгүй. Үр зулзагатайгаа үдийн зоог барьчихдаг. Тэднийг эс тооцвол түүнд дайсан ховор. Газарт бол тэр "хаан" л гэсэн үг. Харсан үзсэн хүмүүс хашхичиж, айж гүйгээд л, хаа таарсан газраа сүү дусааж дайлаад л. Тэр ёстой л нэг жаргалаа эдэлдэг. Шувууд бол өөр. Шүүрч аваад л нисчихдэг. Энэ үед ихэнх могой өөрийнхөө биеийг хамгаалж чаддаггүй. Харин зарим нь өөрсдийгөө хамгаалчихдаг муу аргатай. Тухайлбал, халуун оронд амьдардаг наж хэмээх могой өөр рүү нь дайрсан, таалагдаагүй амьтдыг хашраахаа сайн мэддэг. Тэр дайснаа хороороо нулимж хордуулдаг аж.

# Эхээс түлхүүр үг, өгүүлбэрийг олоорой.

## Дэлдэнхэн туулай



Дэлдэн чихт сонор соргогийн хүчинд хэдэн зулзагаа осол эндэгдэлгүй өсгөнө. Ямар нэг юм ойртон ирж байгааг үнэр, сонсголоосоо гадна биеэрээ анирдан мэдэж чадна. Газарт элэглэн хэвтэж, хаанаас юу дөхөж явааг газраасаа дуулчхаж чаддаг. Аюул ойртоход зулзагануудаа нүхэнд нь оруулах юм уу, эсвэл дэрсний доогуур хошуугаар нь шаалган нуугдуулдаг. Өөрөө дээр дээр дэгдэн харайж зугтан аюулыг төөрүүлнэ. Хөөгдөж хөөгдөж амьд мэнд мултраад ирэхэд нөгөө хэд нь толгойгоо байдгаар нь нуучихсан хэвтэж байдаг аж.

Эм туулайнд бусад амьтдад байдаггүй нэг сайхан чанар бий. Өвсөнд хяраад хэвтчихсэн бөжинтэй таарвал хэний ч хүүхэд байсан ялгаагүй түүнийг хөхүүлж цатгачхаад давхиад одно. Бөжинг дагуулахгүй орхихоо бас мэднэ. Эх нь бөжингээ алдчихвал эрж хайж, цөхөрч, “сөртөн сөнөнө” шүү дээ.



Саргүй шөнө машины гэрэлд орж ирсэн туулай гэрлээс гарч чаддаггүй. Чихээ соотойлгон харайж их л хурдтай зугтаж эхэлнэ. Тэгснээ төдхөн нэг чих нь унжчихна. Нэлээд явснаа нөгөө чих нь унжчихна. Хоёр чих нь сув сул шилэн дээр нь санжганаж, явдал нь саараад эхэлнэ. Шогшиж үзнэ, бүр сүүлдээ хэвтээд өгнө. Тэгж хэвтсэн туулай дахиж босдоггүй юм билээ. Түүний хөл нь тэнийхээ байчихдаг. Их давхиснаас болоод тавхай нь хавдчихна. Хөдөлгөөнгүй хэвтсэнээс хөлд нь цус буучихна. Уг нь гэрэлд жаахан дагуулж байгаад гэрлээ унтраамагц замын хажуу руу годхийн харайгаад алга болдог билээ.